



МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ
АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ХИМИ, ХИМИЙН ТЕХНОЛОГИЙН ХҮРЭЭЛЭНГИЙН
2017 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН,
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТ

Аудитын код: САГ-2018/182/СТА-ТШЗ

2018 он



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

ХИМИ, ХИМИЙН ТЕХНОЛОГИЙН
ХҮРЭЭЛЭНГИЙН ЗАХИРАЛ,
ДОКТОР Л.ЖАРГАЛСАЙХАН
ТАНАА

2018.02.23 № 06/533
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Хими, химийн технологийн хүрээлэнгийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Хими, химийн технологийн хүрээлэнгийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүнгийн тайлан, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Хими, химийн технологийн хүрээлэнгийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгуулалгад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Гол асуудал

2017 онд батлагдсан төсөв болох 1,555,885.2 мянган төгрөгийн зардлыг 5,222.8 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан зөрчил нь санхүүгийн тайлангийн хамааралтай байх, хэмжилт гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.


Үүрэг, хариуцлага

Хими, химийн технологийн хүрээлэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц НАРАНЧИМЭГ





УАГ
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

**ХИМИ, ХИМИЙН ТЕХНОЛОГИЙН ХҮРЭЭЛЭНГИЙН
2017 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

Нэмэлт мэдээлэл авахыг
хүсвэл дараахь хаягаар

АУДИТЫН ТАЙЛАН

Монгол Улсын Үндэсний Аудитын
газар
Засгийн газрын IY байр Улаанбаатар-
46 Бага тойруу 6
Web: www.audit.mn

Санхүүгийн аудитын газрын
захирал бөгөөд Тэргүүлэх аудитор
Ц.Наранчимэг
Утас: 261663
И-мэйл: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер: С.Оюунгэрэл
Утас: 261885
И-мэйл: oyungerels@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Цэрэндорж
Утас: 261740
И-мэйл: tserendorjd@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн:
"Шонхор Үнэлгээ Аудит" ХХК
Утас: 70150001
И-мэйл: Shonkhor.mn@gmail.com

Захирал: Б.Эрдэнэ-Очир
Утас: 99098173
И-мэйл: erdeneochir0711@gmail.com

Аудитын багийн ахлагч:
Аудитор: Б.Эрдэнэ-Очир
Утас: 99098173
И-мэйл: erdeneochir0711@gmail.com

САГ/2018/182/СТА-ТШЗ

Хавсралт 1: Агуулга

Хавсралт 2: Аудитын гэрчилгээ

Хавсралт 3: Менежментийн захидал

Хавсралт 4: Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

Хавсралт 5: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
**ХЯЗГААРЛАЛТАЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

Агуулга

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл	2
2. Байгууллагын хууль эрх зүйн орчин	2
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа	3
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, сорилууд түүний үр дүн	4
5. Материаллаг байдал	4
6. Дотоод хяналт	5
7. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар	5
8. Шилэн дансны мэдээлэл	5
9. Олж тогтоосон гол эрсдэлүүд	6
10. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар	6
11. Аудитаар илэрсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар	6
12. Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар	7
13. Анхаарал татахуйц бусад чухал асуудал	7
14. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд	7
15. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл	7
16. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	7
17. Дүгнэлт	8

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хими, химийн технологийн хүрээлэнгийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд “Шонхор Үнэлгээ Аудит” ХХК гэрээгээр аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хуулийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө хөтөлбөрийн дагуу явуулав.

Хими, химийн технологийн хүрээлэнгийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилго байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Хими, химийн технологийн хүрээлэнгийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитыг 2018 оны 01 дүгээр сарын 31-нээс 2018 оны 2 дугаар сарын 10-ны хооронд хийхээр төлөвлөн “Шонхор Үнэлгээ Аудит” ХХК-ийн аудитын баг хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

Хими, химийн технологийн хүрээлэн нь 2017 оны санхүүгийн тайланг 2018 оны 01 дүгээр сарын 25-нд хүлээн авч үндэсний аудитын газраар аудитын төлөвлөгөө хянуулан аудитаа эхэлж бусад санхүүгийн холбогдох баримт материалуудыг 2018 оны 02 дугаар сарын 02-нд хүлээн авсан.

“Шонхор Үнэлгээ Аудит” ХХК нь жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитыг 2018 оны 2 дугаар сарын 2-ноос 10-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг Хими, химийн технологийн хүрээлэнгийн удирдлагад танилцуулна.

2. Байгууллагын хууль эрх зүйн орчин:

Хими, химийн технологийн хүрээлэнгийн удирдлага нь Төсвийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Шинжлэх ухаан, технологийн тухай хуулиудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

Сангийн сайдын 2017 оны 216 дугаар тушаалаар "Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам" батлагдсан.

Тайлангийн хугацаанд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг бусад гол хууль тогтоомж, түүнд нийцүүлэн гаргасан журам, зааварт онцгой өөрчлөлт ороогүй байна.

3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

ШУА-ийн Хими, химийн технологийн хүрээлэнгийн **Эрхэм зорилго** нь:

- Улс орны өмнө тавигдаж буй химийн томоохон хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх;
- Монгол Улсад химийн аж үйлдвэрийг хөгжүүлэх үндэслэл боловсруулах;
- Олон улсын түвшинг хангасан бүтээл туурвих;
- Шинэ бүтээгдэхүүн бий болгох, мэдлэг, мэдээллийн санг өргөжүүлэх явдал юм.

Эрхэм зорилгоо хэрэгжүүлэхийн тулд туршилтаар баталж болохуйц шинэ мэдлэгийг бий болгож дэлхийн шинжлэх ухаанд хувь нэмэр оруулах, эх орны амьтан, ургамал, эрдсийн гаралтай түүхий эдийн хими, физик-хими, биохими, технологийн шинж чанарыг судлан тодорхойлох, тэдгээрийг хувирган өөрчлөх байгаль орчинд ээлтэй хими, биохимийн дэвшилтэт технологи бий болгох, улмаар өгөгдсөн шинж чанартай шинэ бодис, бэлдмэл, бүтээгдэхүүн үйлдвэрлэх шинжлэх ухааны үндэслэл боловсруулах зорилготой.

Дээрх зорилгын хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлэн ажиллаж байна.

- Хүний нөөцийн чадамжийг байнга дээшлүүлнэ. Дэлхийн болон манай улсын хэмжээний тэргүүлэгч эрдэмтдийн тоог нэмэгдүүлэх, тогтвор, суурьшилтай ажиллах бололцоогоор хангах, залуу судлаачдыг мэдлэг, боловсролоо дээшлүүлэхэд анхааран ажиллах.
- Судалгаа, шинжилгээний үр дүнд бий болсон шинэ технологиудыг үйлдвэрлэлийн хэмжээнд турших, нэвтрүүлэх, тэдгээрийг дотоод, гадаадын зах зээлд өрсөлдөх чадвартай болгон бойжуулах, улмаар гарааны компани байгуулахад нь менежментийн дэмжлэг үзүүлэх.
- Шийдвэр гаргагчид, бодлого боловсруулагчдад шинжлэх ухаан, технологийн асуудлаар зөвлөмж хүргэх, мэдээллээр хангахын зэрэгцээ шинжлэх ухааны мэдлэг, ололт амжилтыг олон түмэнд тайлбарлан таниулах ажлыг шинжлэх ухаанчаар зохион байгуулах.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д "Төсвийн байгууллага нь түүний үйл ажиллагааг үр ашигтай

удирдлагаар хангаж, ажлын үр дүнг хариуцах үүрэг бүхий төсвийн шууд захирагчтай байна” гэж заасан байна.

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4.18-д “төсвийн бусад байгууллагын дарга (захирал, эрхлэгч) тухайн байгууллагын төсвийн шууд захирагч байна” гэж заасны дагуу Хими, химийн технологийн хүрээлэнгийн захирал Төсвийн захирагчийн үүрэг гүйцэтгэж байна. Хими, химийн технологийн хүрээлэнгийн 2017 оны үндсэн үйл ажиллагааны төсвийг Шинжлэх ухааны академи, нэмэлт зардлуудыг төсөл хөтөлбөрүүдээс санхүүжүүлж байна. Төсвийн захирагчтай шууд холбоотой Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг ажилдаа мөрдлөг болгон ажиллаж байна.

4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, сорилууд түүний үр дүн:

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, хуулийг шалгуур болгон ашигласан болно.

Аудитаар Хими, химийн технологийн хүрээлэнгийн 2017 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс төсвийн шууд захирагчийн бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжуулав.

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, материаллаг дүнтэй зарим гүйлгээнүүдийг түүвэрчилсэн байдлаар аудитын 15 горим, сорил гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг БСШУС-ын 2017 оны А/40 дүгээр тушаалаар батлан мөрдүүлж байна.

Хими, химийн технологийн хүрээлэнгийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах, програмд нэвтрэх зэрэг аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэсэн болно. /ТАБ-СТА-В-2/

Санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, боловсруулах үйл ажиллагааг "Accolus" санхүүгийн програмыг ашиглан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг бэлтгэн гаргасан байна.

5. Материаллаг байдал

Гүйцэтгэлийн шатанд төлөвлөлтийн үе шатны материаллаг байдлын дүнг өөрчлөөгүй бөгөөд 2017 оны нийт зардлын гүйцэтгэлийг суурь болгон сонгож



материаллаг байдлын түвшинг 1,995,893.5 мянган төгрөгийн зардлын 1 хувиар буюу 19,958.9 мянган төгрөгөөр тооцсон.

6. Дотоод хяналт

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Хими, химийн технологийн хүрээлэнгийн дотоод хяналтын эрсдэлийн 9 эрсдэл үр нөлөөгүй байж болзошгүй гэж тооцон эдгээр эрсдэлийг хянахад материаллаг эрсдэлтэй асуудал илрээгүй болно. /ТАБ-СТА-А-4-өөс үзнэ үү/

7. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар

2017 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу тус байгууллагын Төрийн сан банкин дахь харилцах дансаар олгож, төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэл, төсвийн зардлын төрөл зүйлээр хуваарилан зарцуулалтанд хяналт тавьж ажилласан байна.

Хими, химийн технологийн хүрээлэнгийн үйл ажиллагааны төсөв 2017 онд 1,555,885.2 мянган төгрөгөөр батлагдаж гүйцэтгэлээрх 1,561,108.0 мянган төгрөгийн зардал гаргаж төсвийг 5,222.8 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан. 2017 онд үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө 16,600.0 мянган төгрөгөөр батлагдсан нь 10,044.7 мянган төгрөгөөр давж биелсэн. Үндсэн үйл ажиллагааны үр дүн болох 4,821.9 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт санхүүжилтээр 2017 онд 325,492.4 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж 325,492.4 мянган төгрөгийн зардал гаргахаар Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2017 оны А/48 тоот тушаалаар баталсан. 2017 онд 514,791.5 мянган төгрөгийн нэмэлт орлоготой ажиллаж 189,299.1 мянган төгрөгөөр нэмэлт орлогын төлөвлөгөө давж биелсэн. Нэмэлт үйл ажиллагаанаас 131,766.0 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Авлага 132,175.9 мянган төгрөгийн үлдэгдэлтэй гарсаны 131,763.0 мянган төгрөг нь нэмэлт санхүүжилтийн 2018 онд төлөгдөх хэсгийг тооцоо нийлж баталгаажуулан авлагаар бүртгэсэн байна.

Тайланд тусгасан Эрдэс боловсруулалт, технологийн хүрээлэнгээс нэгдэх үед балансаас балансад шилжиж ирсэн 16,000.0 мянган төгрөгийн үнэ бүхий Краз машины асуудал шүүхээр эцэслэн шийдвэрлэгдээгүй байна.

8. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны цахим хуудас болох www.shilendans.gov.mn хуудсанд 2017 оны батлагдсан төсөв, төсвийн гүйцэтгэл оруулсан байна.

Байгууллагын цахим хуудсанд байгууллагын мэдээлэлүүд, 2017 оны төсвийн

гүйцэтгэлийг оруулсан байна.

9. Олж тогтоосон гол эрсдэлүүд

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 24 эрсдэлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр, нийт 29 горим, сорил гүйцэтгэж доорхи эрсдэлүүдийг олж тогтоов. /ТАБ-СТА-В-3-аас үзнэ үү/

10. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар

Тайлант хугацаанд анхаарал татах гол, онцлог гүйлгээ гараагүй болно.

11. Аудитаар илэрсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн асуудлуудыг дараах заалтуудад хураангуйлан тэмдэглэв.

Аудитын явцад материаллаг хэмжээтэй алдаа зөрчлүүд нь санхүүгийн тайлангийн оршин байх, эрх үүрэг, тохиолдсон байх, үнэн зөв гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байсан ба холбогдох хуулийн заалтуудыг зөрчсөн байна.

Үүнд:

1. Барилгын элэгдлийг 60 жилээр, "барилга 2-р байр"-ын элэгдлийг 10 жилээр тооцсон байна. Энэ нь БСШУС-ын сайдын 2017 оны А/40 дүгээр тушаалаар батлагдсан "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-т барилгын элэгдлийг 50 жилээр байгуулна" гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж ажиллах, журмын 2.3 заалтыг биелүүлэх, элэгдлийн зардлыг тооцож залруулах талаар зөвлөмж хүргүүлэх;

2. Конторын барилгын их засварын зардал болох 45,705.9 мянган төгрөгийг "Их засвар" нэрээр шинэ үндсэн хөрөнгө үүсгэн бүртгэсэн бөгөөд элэгдэл тооцоогүй байна. Энэ нь Сангийн сайдын 2007 оны 326 дугаар тушаалаар батлагдсан "Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын 4.30-д "Үндсэн хөрөнгийн засварын зардал нь үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг уртасгах гэх мэт уг хөрөнгөөс хүртэх эдийн засгийн өгөөжийг нэмэгдүүлж байвал уг зардлыг капиталжуулан үндсэн хөрөнгийн анхны өртгийг нэмэгдүүлнэ" гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Харьяалагдах үндсэн хөрөнгийн анхны өртгийг нэмэгдүүлж капиталжуулах, элэгдлийн тооцоог давтан гүйцэтгэх талаар зөвлөмж хүргүүлэх;

3. Номын фондод үндсэн хөрөнгийн шинж чанар хангахгүй бараа материалын шинжтэй тараах материал, судалгааны ажлууд зэргийг бүртгэсэн байна.

Шийдвэрлэсэн нь: Номын фондын ангиллыг дахин хийж үндсэн хөрөнгийн

шинж чанаргүй зүйлсийг ангилан холбогдох байгууллагаар батлуулан үндсэн хөрөнгөөс хасч холбогдох ангиллаар өөрчлөн бүртгэх талаар зөвлөмж хүргүүлэх;

4. 2017 онд 41,064.0 мянган төгрөгийн түрээс, шинжилгээний орлогыг хамтад нь 1200041 тоот дансанд мөнгөн сууриар хуримтлуулан бүртгэсэн. Энэ нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан “Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын 2.6-д “Байгууллага нь дансны нэгдсэн жагсаалт дахь төсөвт байгууллагын ажил үйлчилгээний орлогыг өөрийн үйл ажиллагааны онцлогоос хамааран орлогын нэр төрлөөр нь ангилан бүртгэнэ. Үүнд: түрээсийн, төлбөртэй ажил үйлчилгээний, бараа борлуулсаны орлого гэх мэт” гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Түрээс болон шинжилгээний орлогыг аккруэл сууриар бүртгэх, орлогын дансыг түрээс, шинжилгээний орлогуудыг тусгайлан харж болохоор ангилж бүртгэхийг талаар зөвлөмж хүргүүлэх;

5. 2017 онд Шинжлэх ухаан технологийн сангийн захирлын 2 удаагийн, Шинжлэх ухааны академийн ерөнхийлөгчийн 4 удаагийн буюу нийт 6 удаагийн худалдан авах зөвшөөрлөөр 52,224.5 мянган төгрөг, Хандиваар нийт 59,275.1 мянган төгрөг, нийт 111,499,6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө орлогод авсан байна. Энэ нь “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх” журмын 1.2-т “... эд хөрөнгө олж авах, бүртгэх, ... шилжүүлэх тухай саналаа ... Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт тавьж шийдвэрлүүлнэ” гэж заасныг зөрчсөн.

Шийдвэрлэсэн нь: “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх” журмыг мөрдөж ажиллах талаар зөвлөмж хүргүүлэх;

12. Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар

Үндсэн хөрөнгийн элэгдэлтэй холбоотой алдааг залруулаагүй бөгөөд “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийн 2.3-т заасны дагуу үндсэн хөрөнгийн ашиглах хугацаа, элэгдлийн хувийг батлуулснаар 2018 онд залруулна” гэсэн хариу ирүүлсэн.

13. Анхаарал татахуйц бусад чухал асуудал

Анхаарал татахуйц бусад асуудал байгаагүй болно.

14. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд

Нэмэлт санхүүжилтийн төсөв, гүйцэтгэлийг анхаарах хэрэгтэй.

15. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл

Хими, химийн технологийн хүрээлэнгийн 2017 оны санхүүгийн тайлангийн аудитаар хөрөнгийн элэгдэл байгуулахтай холбоотой 56,555.5 мянган төгрөг,

хөрөнгө капиталжуулалттай холбоотой 45,705.9 мянган төгрөгийн зөрчил илэрсэн ба хөрөнгийн ангилал зөрүүтэй, түрээс шинжилгээний орлогуудыг тусгайлан ангилаагүй нийлүүлэн бүртгэсэн зэрэг 5 зөрчилд 2 зөвлөмж өгсөн болно.

16. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх аудитыг “Бест фортуна Аудит” ХХК гүйцэтгэж 4 зөвлөмж өгсөн. Эдгээр 4 зөвлөмжөөс 3 зөвлөмжийг биелүүлж, 1 зөвлөмжийг бүрэн биелүүлээгүй байна.

17. “Хязгаарлалттай” санал дүгнэлт

Хими, химийн технологийн хүрээлэнгийн үйл ажиллагааны зардалд 2017 онд батлагдсан төсөв болох 1,555,885.2 мянган төгрөгийн зардлыг 5,222.8 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан нь хамааралтай байх, хэмжилт гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Дээрх алдаа зөрчлийг эс тооцвол Хими, химийн технологийн хүрээлэнгийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн байдал, санхүүгийн үр дүнгийн тайлан, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон илчлэл тодруулгуудад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.



УАГ
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

**ХИМИ, ХИМИЙН ТЕХНОЛОГИЙН ХҮРЭЭЛЭНГИЙН
2017 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Монгол Улсын Үндэсний Аудитын
газар
Засгийн газрын IY байр Улаанбаатар-
46 Бага тойруу 6
Web: www.audit.mn

Санхүүгийн аудитын газрын
захирал бөгөөд Тэргүүлэх аудитор
Ц.Наранчимэг
Утас: 261663
И-мэйл: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер: С.Оюунгэрэл
Утас: 261885
И-мэйл: oyungerels@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Цэрэндорж
утас: 261740
И-мэйл: tserendorjd@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн:
"Шонхор Үнэлгээ Аудит" ХХК
Утас: 70150001
И-мэйл: www.shonkhor.mn

Захирал: Б.Эрдэнэ-Очир
Утас: 99098173
И-мэйл: erdeneochir0711@gmail.com

Чанарын хяналтын мэргэжилтэн,
Аудитор: З.Эрдэнэжаргал
Утас: 99240809
И-мэйл: Shonkhor.mn@gmail.com

Тэргүүлэх ач холбогдол №1

Асуудал 1: Үндсэн хөрөнгө

Тэргүүлэх ач холбогдол №2

Асуудал 1: Орлогын ангилал

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ХЯЗГААРЛАЛТАЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

Менежментийн захидал

Үндэсний аудитын газар аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг Хими, химийн технологийн хүрээлэнгийн удирдлагад зориулан бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгасан болно.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим сорил нь санхүүгийн тайлан, илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Тиймээс аудитын зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Энэхүү зөвлөмж танай байгууллагын бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад хамтран ажилласан удирдлага болон бусад ажилтнуудад талархал илэрхийлье.



Асуудал 1: Үндсэн хөрөнгө

Аудитын ажиглалт

1. Барилгын элэгдлийг 60 жил, “барилга 2-10 жилээр тооцсон байна. Энэ нь БСШУС-ын сайдын р байр”-ын элэгдлийг 2017 оны А/40 дүгээр тушаалаар батлагдсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-т барилгын элэгдлийг 50 жилээр байгуулна” гэж заасныг зөрчсөн байна.

2. Конторын барилгын их засварын зардал болох 45,705.9 мянган төгрөгийг “Их засвар” нэрээр шинэ үндсэн хөрөнгө үүсгэн бүртгэсэн бөгөөд элэгдэл тооцоогүй байна. Энэ нь Сангийн сайдын 2007 оны 326 дугаар тушаалаар батлагдсан “Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын 4.30-д “Үндсэн хөрөнгийн засварын зардал нь үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг уртасгах гэх мэт уг хөрөнгөөс хүртэх эдийн засгийн өгөөжийг нэмэгдүүлж байвал уг зардлыг капиталжуулан үндсэн хөрөнгийн анхны өртгийг нэмэгдүүлнэ” гэж заасныг зөрчсөн байна.

3. Номын фондод үндсэн хөрөнгийн шинж чанар хангахгүй бараа материалын шинжтэй тараах материал, судалгааны ажлууд зэргийг бүртгэсэн байна.

4. 2017 онд Шинжлэх ухаан технологийн сангийн захирлын 2 удаагийн, Шинжлэх ухааны академийн ерөнхийлөгчийн 4 удаагийн зөвшөөрлөөр нийт 52,224.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан байна. Энэ нь “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх” журмын 1.2-т “... эд хөрөнгө олж авах, бүртгэх, ... шилжүүлэх тухай саналаа ... Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт тавьж шийдвэрлүүлнэ” гэж заасныг зөрчсөн байна.

Эрсдэл

Санхүүгийн тайлан дахь хөрөнгийн дүн буруу илэрхийлэгдэх, зардал буруу тооцоологдох ижил ашиглалттай хөрөнгүүдийн хувьд үнэ цэнийн зөрүү ихээр үүснэ. Энэ нь бодитой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Тэргүүлэх ач холбогдол №1

Аудитын зөвлөмж

1.Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж ажиллах, журмын 2.3 заалтыг биелүүлэх, элэгдлийн зардлыг тооцож залруулах;

2. Харьяалагдах үндсэн хөрөнгийн өртөгт капиталжуулах, элэгдлийн тооцоог давтан гүйцэтгэх;

3. Номын фондын ангиллыг дахин хийж үндсэн хөрөнгийн шинж чанаргүй зүйлсийг ангилан холбогдох байгууллагаар батлуулан үндсэн хөрөнгөөс хасч холбогдох ангиллаар өөрчлөн бүртгэх;

4. Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх” журмыг мөрдөж ажиллах;

Үйлчлүүлэгчийн хариу

Асуудлын үйлчлүүлэгчийн санхүүгийн танилцуулсан болно. Бүртгэлийг удирдлага, ажилтанд санал дүгнэлт.



Асуудал 1: Орлогын ангилал

Аудитын ажиглалт

2017 онд 41,064.0 мянган төгрөгийн түрээс, шинжилгээний орлогыг хамтад нь 1200041 тоот дансанд мөнгөн сууриар хуримтлуулан бүртгэсэн. Энэ нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан “Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын 2.6-д “Байгууллага нь дансны нэгдсэн жагсаалт дахь төсөвт байгууллагын ажил үйлчилгээний орлогыг өөрийн үйл ажиллагааны онцлогоос хамааран орлогын нэр төрлөөр нь ангилан бүртгэнэ. Үүнд: түрээсийн, төлбөртэй ажил үйлчилгээний, бараа борлуулсаны орлого гэх мэт” гэж заасныг зөрчсөн байна.

Эрсдэл

Түрээсийн орлого нь өмчийн, шинжилгээний орлого нь үйл ажиллагааны шинж чанартай орлого юм. Түрээсийн орлогын 30 хувийг төсөвт шууд төвлөрүүлдэг тул тусгайлан тооцох шаардлагатай, шинжилгээний орлогыг тусгайлан хяналт тавих шаардлагатай байхад ийнхүү нийлүүлэн нэг дансаар бүртгэж байгаа нь эдгээр орлогуудыг ялгаж тооцоход хүндрэл учруулж байна. Энэ нь үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Тэргүүлэх ач холбогдол №2

Аудитын зөвлөмж

Түрээс болон шинжилгээний орлогыг аккруэл сууриар бүртгэх, орлогын дансыг түрээс, шинжилгээний орлогуудыг тусгайлан харж болохоор ангилж бүртгэх

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 5 дугаар сарын 25-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.

Үйлчлүүлэгчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ХЯЗГААРЛАЛТАЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

ХИМИ, ХИМИЙН ТЕХНОЛОГИЙН ХҮРЭЭЛЭН

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

2017 оны 12 сарын 31 өдөр.

/төгрөгөөр/

Код	ҮЗҮҮЛЭЛТ	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
	МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ		
3121	Төгрөг		
31211	Төрийн сангийн харилцах		
33	АВЛАГА	26,760,944.00	132,175,923.22
3351	Татаас санхүүжилтын авлага	26,760,944.00	131,762,979.00
	Байгууллагаас авах авлага		412,944.22
34	УРЬДЧИЛГАА		68,703,830.00
34600	Урьдчилж гарсан зардал		66,297,930.00
34714	Томилолтын урьдчилгаа		2,405,900.00
35	БАРАА МАТЕРИАЛ	80,954,497.69	78,419,000.42
351	Түүхий эд материал	18,823,704.13	12,491,898.86
35110	Тусгай зориулалттай материал	18,823,704.13	12,491,898.86
354	Хангамжийн материал	62,130,793.56	65,927,101.56
35410	Бичиг хэргийн материал	2,218,667.00	1,517,867.00
35430	Сэлбэг хэрэгсэл	43,693,434.20	48,262,634.20
35440	Түлш тослох материал		217,000.00
35470	Бусад хангамжийн материал	16,218,692.36	15,929,600.36
	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	107,715,441.69	279,298,753.64
	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ		
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,885,588,090.21	1,831,346,814.20
392	Биет хөрөнгө	1,884,906,427.74	1,830,339,318.39
39201	Барилга, байгууламж	2,662,785,486.10	2,662,785,486.10
39202	Хуримтлагдсан элэгдэл	(1,007,629,189.11)	(1,117,440,432.51)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	31,913,000.00	31,913,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(28,292,426.81)	(30,057,926.61)
39205	Машин, тоног төхөөрөмж	2,174,814,166.27	2,158,958,149.37
39206	Хуримтлагдсан элэгдэл	(1,988,488,995.31)	(1,909,740,198.58)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	148,759,991.42	141,359,780.25
39208	Хуримтлагдсан элэгдэл	(124,142,532.73)	(122,262,967.58)
39217	Номын фонд	13,042,136.16	13,042,136.16
39214	Бусад үндсэн хөрөнгө	2,900,000.00	2,900,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(755,208.25)	(1,117,708.21)
392	Биет бус хөрөнгө	681,662.47	1,007,495.81
39301	Програм хангамж	3,270,000.00	3,820,000.00
39302	Хасагдуулга	(2,588,337.53)	(2,812,504.19)
	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,885,588,090.21	1,831,346,814.20
	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,993,303,531.90	2,110,645,567.84
	ЦЭВЭР ХӨРӨНГӨ / ӨМЧИЙН ДҮН	1,993,303,531.90	2,110,645,567.84
51	Засгийн газрын хувь оролцоо	1,993,303,531.90	2,110,645,567.84
	Засгийн газрын оруулсан капитал /ЗГСан/	3,077,104,818.51	3,077,104,818.51
51101	Өмч: -Төрийн өмч	3,077,104,818.51	3,077,104,818.51
	Хуримтлагдсан үр дүн	(1,896,733,017.18)	(1,779,390,981.24)
51210	Өмнөх үеийн үр дүн	(1,896,733,017.18)	(1,896,733,017.18)
51220	Тайлант үеийн үр дүн		117,342,035.94
51300	Дахин үнэлгээний зөрүү	812,931,730.57	812,931,730.57
	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ / ӨМЧИЙН ДҮН	1,993,303,531.90	2,110,645,567.84

ХИМИ, ХИМИЙН ТЕХНОЛОГИЙН ХҮРЭЭЛЭН

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

2017 оны 12 сарын 31 өдөр.

Код	ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх он	Тайлант он /төгрөгөөр/
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО	1,936,162,618.00	2,113,235,521.62
	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	12,088,868.00	85,919,751.80
	Нийтлэг татварын бус орлого	12,088,868.00	85,919,751.80
	Төсөвт байгууллагын өөрийн орлого	12,088,868.00	85,919,751.80
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	12,088,868.00	26,644,660.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого		59,275,091.80
	Тусламж, санхүүжилтийн орлого	1,924,073,750.00	2,027,315,769.82
	Улсын төвлөрсөн төсвөөс	1,789,352,900.00	1,539,285,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,789,352,900.00	1,539,285,200.00
	Нэмэлт санхүүжилтийн орлого	134,720,850.00	488,030,569.82
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бусад этгээдээс авсан хандив		187,364,040.00
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан	23,945,000.00	285,560,500.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд	110,775,850.00	15,106,029.82
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,003,156,418.16	1,995,893,485.68
	УРСГАЛ ЗАРДАЛ	2,001,976,418.16	1,952,162,712.33
	Бараа , ажил үйлчилгээний зардал	2,001,976,418.16	1,952,162,712.33
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	1,235,685,372.75	1,216,582,068.08
210101	Цалин	1,190,646,972.75	1,162,472,468.08
210102	Нэмэгдэл цалин		9,435,100.00
210103	унаа, хоолны хөнгөлөлт	45,038,400.00	44,674,500.00
	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	133,102,267.68	138,409,379.64
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	133,102,267.68	94,145,509.64
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл		11,745,500.00
210203	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл		9,312,841.00
210204	Ажилгүйдлын даатгалын шимтгэл		2,107,987.00
210205	Эрүүл мэндийн даатгалын шимтгэл		21,097,542.00
	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	98,363,118.97	83,394,199.74
210301	Гэрэл цахилгааны зардал	38,881,624.00	31,833,459.00
210302	Түлш халаалтын зардал	47,609,897.97	39,521,599.03
210303	Цэвэр бохир усны зардал	11,871,597.00	12,039,141.71
	Хангамж, бараа материалын зардал	6,123,005.23	5,774,351.12
210401	Бичиг хэргийн материал	105,000.00	189,340.00
210402	Тээвэр, шатахууны зардал	1,545,792.00	826,000.00
210403	Шуудан холбоо, интернэтийн зардал	2,854,283.23	2,806,196.12
210404	Ном, хэвлэлийн зардал	1,056,500.00	399,500.00
210406	Бага үнэтэй түрэн элэгдэх зүйлс	561,430.00	1,553,315.00
	Нормативт зардал	1,582,340.00	11,697.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,582,340.00	11,697.00
	Эд хогшил, урсгал засварын зардал	21,557,500.00	24,578,900.00
210604	Урсгал зардал	21,557,500.00	24,578,900.00
	Томилолт, зочны зардал	35,653,500.00	36,367,400.00
210701	Гадаад томилолтын зардал		14,833,400.00
210702	Дотоод томилолтын зардал	35,653,500.00	21,534,000.00
	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төрөл	206,349,171.05	204,456,087.18
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил	204,513,471.05	201,920,387.18
210802	Аудит, баталгаажуулалт зэрэг тогтоох зардал	900,000.00	1,600,000.00
210804	Тээврийн хэрэгслийн зардал	70,100.00	70,100.00

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ХЯЗГААРЛАЛТАЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

210806	Мэдээллийн технологийн үйлчилгээний		
210807	Газрын төлбөр	865,600.00	865,600.00
	Бараа үйлчилгээний бусад зардал	263,560,142.48	242,588,629.57
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	99,796,793.37	52,973,679.76
210902	Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын	10,943,800.00	23,874,052.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	152,819,549.11	165,740,897.81
	Бусад урсгал шилжүүлэг	-	38,905,903.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмж		2,602,953.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		36,302,950.00
	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,180,000.00	4,824,870.35
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,180,000.00	4,824,870.35
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	(66,993,800.16)	117,342,035.94
	НИЙТ ҮР ДҮН	(66,993,800.16)	117,342,035.94

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ХЯЗГААРЛАЛТАЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

ХИМИ, ХИМИЙН ТЕХНОЛОГИЙН ХҮРЭЭЛЭН

АУДИТ ХИЙГДСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

Д/Д	ҮЗҮҮЛЭЛТ	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2015 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	3,077,104,818.51	812,931,730.57	(1,829,739,217.02)	2,060,297,332.06
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,077,104,818.51	812,931,730.57	(1,829,739,217.02)	2,060,297,332.06
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				
5	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
7	Тайлант үеийн үр дүн			(66,993,800.16)	(66,993,800.16)
8	2016 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	3,077,104,818.51	812,931,730.57	(1,896,733,017.18)	1,993,303,531.90
9	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
10	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,077,104,818.51	812,931,730.57	(1,896,733,017.18)	1,993,303,531.90
11	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				
12	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				
13	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
14	Тайлант үеийн үр дүн			117,342,035.94	117,342,035.94
15	2017 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	3,077,104,818.51	812,931,730.57	(1,779,390,981.24)	2,110,645,567.84



ХИМИ, ХИМИЙН ТЕХНОЛОГИЙН ХҮРЭЭЛЭН

АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2017 оны 12 сарын 31 өдөр.

/төгрөгөөр/

Код	ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх он	Тайлант он
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ОРЛОГО (I)	1,988,927,710.18	2,118,030,643.82
	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	12,474,641.18	37,364,371.00
	Нийтлэг татварын бус орлого	12,474,641.18	37,364,371.00
	Төсөвт байгууллагын өөрийн орлого	12,474,641.18	37,364,371.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлого	12,088,868.00	29,842,360.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлого	385,773.18	7,522,011.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,976,453,069.00	2,080,666,272.82
	Улсын төвлөрсөн төсвөөс	1,789,352,900.00	1,539,285,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,789,352,900.00	1,539,285,200.00
	Нэмэлт санхүүжилтийн орлого	164,580,930.00	514,791,513.82
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс		214,124,984.00
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан	23,945,000.00	285,560,500.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны	140,635,930.00	15,106,029.82
134001	Нийгмийн даатгалын сангаас төсвөөс санхүүжих	22,519,239.00	26,589,559.00
	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	22,519,239.00	26,589,559.00
	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	1,898,100,700.18	2,065,806,113.82
	УРСГАЛ ЗАРДАЛ	1,898,100,700.18	2,065,806,113.82
	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,847,640,517.18	1,890,312,361.47
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	1,235,685,372.75	1,243,171,627.08
210101	Үндсэн цалин	1,190,646,972.75	1,189,062,027.08
210102	Нэмэгдэл цалин		9,435,100.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	45,038,400.00	44,674,500.00
	Ажил олгогчоос НД-д төлөх шимтгэл	133,102,267.68	138,409,379.64
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	133,102,267.68	94,145,509.64
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл		11,745,500.00
210203	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл		9,312,841.00
210204	Ажилгүйдлын даатгалын шимтгэл		2,107,987.00
210205	Эрүүл мэндийн даатгалын шимтгэл		21,097,542.00
	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	103,199,827.97	83,394,199.74
210301	Гэрэл цахилгааны зардал	39,881,624.00	31,833,459.00
210302	Түлш, халаалтын зардал	50,133,001.97	39,521,599.03
210303	Цэвэр, бохир усны зардал	13,185,202.00	12,039,141.71
	Хангамж, бараа материалын зардал	6,890,985.23	14,734,921.12
210301	Бичиг хэргийн материал	253,000.00	2,275,740.00
210302	Тээвэр, шатахууны зардал	1,545,792.00	1,763,000.00
210303	Шуудан холбооны зардал	2,854,283.23	2,806,196.12
210304	Ном, хэвлэлийн зардал	1,281,500.00	849,500.00
210306	Бага үнтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	956,410.00	7,040,485.00
	Норматив зардал	2,100,000.00	1,796,597.00
210503	Норматив хувцас, зөөлөн эдлэл	2,100,000.00	1,796,597.00
	Эд хогшил, урсгал засварын зардал	21,557,500.00	77,971,900.00
210601	Багаж техник хэрэгсэл		45,000,000.00
210604	Урсгал засвар	21,557,500.00	32,971,900.00
	Томилолт, зочны зардал	35,653,500.00	38,773,300.00
210701	Гадаад албан томилолт		17,239,300.00
210702	Дотоод албан томилолт	35,653,500.00	21,534,000.00
	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр	241,432,890.55	255,399,173.89
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр	239,597,190.55	252,863,473.89
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	900,000.00	1,600,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	70,100.00	70,100.00



210807	Газрын төлбөр	865,600.00	865,600.00
	Бараа үйлчилгээний бусад зардал	68,018,173.00	36,661,263.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	57,074,373.00	12,587,211.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10,943,800.00	24,074,052.00
	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	50,460,183.00	175,493,752.35
	Бусад урсгал шилжүүлэг	22,519,239.00	38,905,903.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмж	22,519,239.00	2,602,953.00
213209	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал		36,302,950.00
	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	27,940,944.00	136,587,849.35
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	27,940,944.00	136,587,849.35
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	90,827,010.00	52,224,530.00
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ГҮЙЛГЭЭ		
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ГҮЙЛГЭЭ	90,827,010.00	52,224,530.00
	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	90,827,010.00	52,224,530.00
	Дотоод эх үүсвэр	90,827,010.00	52,224,530.00
	Биет ба биет бус хөрөнгө худалдан авах зардал	90,827,010.00	52,224,530.00
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(90,827,010.00)	(52,224,530.00)
	САНХҮҮГИЙН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ ДҮН		
	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

ХИМИ, ХИМИЙН ТЕХНОЛОГИЙН ХҮРЭЭЛЭН

АУДИТ ХИЙГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Төлөвлөгөө	ГҮЙЦЭТГЭЛ	Хэтрэлт, хэмнэлт	Хувь
I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН				
II. НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН				
IV. УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	1,555,885,200.00	1,561,107,992.28	5,222,792.28	100.3%
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,164,127,000.00	1,163,918,854.51	(208,145.49)	100.0%
Цалин	1,012,939,400.00	1,109,809,254.51	96,869,854.51	109.6%
Нэмэгдэл цалин	104,721,200.00	9,435,100.00	(95,286,100.00)	9.0%
унаа, хоолны хөнгөлөлт	46,466,400.00	44,674,500.00	(1,791,900.00)	96.1%
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	133,378,400.00	132,802,235.91	(576,164.09)	99.6%
Тэтгэврийн даатгалын шимтгэл	86,772,400.00	88,538,365.91	1,765,965.91	102.0%
Тэтгэмжийн даатгалын шимтгэл	11,651,500.00	11,745,500.00	94,000.00	100.8%
ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	9,321,200.00	9,312,841.00	(8,359.00)	99.9%
Ажилгүйдлын даатгалын шимтгэл	2,330,300.00	2,107,987.00	(222,313.00)	90.5%
Эрүүл мэндийн даатгалын шимтгэл	23,303,000.00	21,097,542.00	(2,205,458.00)	90.5%
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	83,394,200.00	83,394,199.74	(0.26)	100.0%
Гэрэл цахилгааны зардал	29,118,000.00	31,833,459.00	2,715,459.00	109.3%
Түлш халаалтын зардал	40,876,100.00	39,521,599.03	(1,354,500.97)	96.7%
Цэвэр бохир усны зардал	13,400,100.00	12,039,141.71	(1,360,958.29)	89.8%
Хангамж, бараа материалын зардал	12,457,000.00	13,932,121.12	1,475,121.12	111.8%
Бичигхэргийн материал	1,660,000.00	1,472,940.00	(187,060.00)	88.7%
Тээвэр, шатахууны зардал	1,440,000.00	1,763,000.00	323,000.00	122.4%
Шуудан холбоо, интернэтийн зардал	2,700,000.00	2,806,196.12	106,196.12	103.9%
Ном, хэвлэлийн зардал	407,000.00	849,500.00	442,500.00	208.7%
Бага үнэтэй түрэн элэгдэх зүйлс	6,250,000.00	7,040,485.00	790,485.00	112.6%
Нормативт зардал	1,800,000.00	1,796,597.00	(3,403.00)	99.8%
Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,800,000.00	1,796,597.00	(3,403.00)	99.8%
Эд хогшил худалдан авах	76,490,000.00	77,971,900.00	1,481,900.00	101.9%
Багаж, техник хэрэгсэл	45,000,000.00	45,000,000.00	-	100.0%
Урсгал засвар	31,490,000.00	32,971,900.00	1,481,900.00	104.7%
Томилолт, зочны зардал	1,500,000.00	1,500,000.00	-	100.0%
Гадаад томилолтын зардал				
Дотоод томилолтын зардал	1,500,000.00	1,500,000.00	-	100.0%
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	37,435,600.00	44,059,186.00	6,623,586.00	117.7%
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил	34,880,000.00	41,523,486.00	6,643,486.00	119.0%
Аудит, баталгаажуулалт зэрэг тогтоох зардал	1,600,000.00	1,600,000.00	-	100.0%
Тээврийн хэрэгслийн татвар	80,000.00	70,100.00	(9,900.00)	87.6%
Газрын төлбөр	865,600.00	865,600.00	-	100.0%
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	10,000.00		(10,000.00)	0.0%
Бараа үйлчилгээний бусад зардал	4,600,000.00	4,599,995.00	(5.00)	100.0%
Бараа үйлчилгээний бусад зардал				
Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын	4,600,000.00	4,599,995.00	(5.00)	100.0%
ТАТААС	40,703,000.00	37,132,903.00	(3,570,097.00)	91.2%
Бусад урсгал шилжүүлэг	40,703,000.00	37,132,903.00	(3,570,097.00)	91.2%
Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	2,603,000.00	2,602,953.00	(47.00)	100.0%
Нэг удаагийн тэтгэмж, урамшуулал	38,100,000.00	34,529,950.00	(3,570,050.00)	90.6%
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,555,885,200.00	1,561,107,992.28	5,222,792.28	100.3%
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	16,600,000.00	26,644,660.00	10,044,660.00	160.5%
Дээд шатны төсвийн захирагчаас			-	
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,539,285,200.00	1,534,463,332.28	(4,821,867.72)	99.7%
Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл				
Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл				
БАЙГУУЛЛАГЫН ТОО				
АЖИЛЛАГСАД БҮГД	127	127		
Удирдах ажилтан	1	1		
Гүйцэтгэх ажилтан	99	99		
Үйлчлэх ажилтан	27	27		
СУРАЛЦАГСАД /жилийн дунджаар/				
Ерөнхий боловсролын сургуульд суралцагсад				